

**БҮГД НАЙРАМДАХ ТРИНИДАД БА ТОБАГО УЛСЫН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Товч танилцуулга: Тринидад, Тобаго хэмээх 2 арлаас бүрдэх тус улс 1962 онд Их Британийн колончлолоос гарч тусгаар тогтнон, НҮБ-ын гишүүнээр элссэн. Тринидад ба Тобаго улс нь Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг, Карибын хамтын нийгэмлэг, Америкийн улсуудын байгууллагын гишүүн юм. Тус улс олон улсын хурал чуулган, санал хураалтад аль нэг улс, бүлгээс хамааралгүй бие даасан санал өгдөг гэж өөрийгөө тодорхойлдог ч АНУ, Европын Холбоог дэмжиж санал өгөх нь бий.	
Нутаг дэвсгэр	5,130 км ²
Хүн ам	Хүн амын тоо: 1,405,646 (2022 он) Бүтэц, үндэстэн ястны эзлэх хувь: нутгийн уугуул Зүүн Энэтхэг 35.4%, африк 34.2%, холимог 22.8%, бусад/тодорхойгүй 6.2%, европ, хятад, араб 1.3%. Хүн амын өсөлт: 0.14 хувь (2022 он) Дундаж наслалт: 73.9 (эм-76.7, эр-71.2) Төрийн албан ёсны хэл: англи
Шашин	63.2% христ, 20.4% хинду, 8.3% бусад, 5.6% муслим, 2.5% шашин шүтдэггүй
Нийслэл	Порт-оф-Спейн хот (545,045 хүн амтай)
Засаг захиргааны нэгж	14 мужаас бүрддэг
Үндэсний баяр	08 дугаар сарын 31
Улс төрийн тогтолцоо	
Засаглалын хэлбэр	Парламентын Бүгд Найрамдах Улс
Ерөнхийлөгч	Кристин Кангалоо (2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс)
Парламентын удирдлага	Сенатын дарга Нигел де Фрейтас (2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс) Төлөөлөгчдийн танхимын дарга Брижид Аннисетт-Жорж (2015 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс)
Ерөнхий сайд	Кэйт Роулэй (2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс)
Гадаад хэргийн сайд	Амери Бровн (2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс)
Хууль тогтоох засаглал	Конгрессын дээд танхим 31, доод танхим 41 суудалтай
Сонгуулийн тогтолцоо	Шууд сонгуулиар 5 жилийн хугацаатай сонгогддог.
Улс төрийн гол намууд	Ард түмний үндэсний хөдөлгөөн (People's National Movement) Ард түмний түншлэлийн эвсэл (People's Partnership Coalition) Нэгдсэн үндэсний конгресс (United National Congress)
Эдийн засгийн үзүүлэлтүүд	
Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/	28 тэрбум ам.доллар (2023 он)
Дундаж цалин /сарын/	9800 тринидад ба тобаго доллар = 1470 ам. доллар
Эдийн засгийн гол салбарууд	Үйлчилгээний салбар 55.11% Аж үйлдвэрийн салбар 42% Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбар 1.03%
Төсвийн алдагдал	2.7 % (2024 онд ДНБ-ий)

Инфляцийн түвшин	0.5% (2024 он)
Хөдөлмөр эрхлэлт	Хөдөлмөр эрхлэгчдийн тоо 571,300 (2024 он) Нийт ажил эрхлэгчдийн 85.4% нь үйлчилгээний салбарт, 11.5% нь аж үйлдвэрийн салбарт, 3.1% нь хөдөө аж ахуйн салбарт тус тус харьяалагддаг. Ажилгүйдлийн түвшин: 4.1% (2024 он)
Гадаад худалдаа	<u>Экспортын гол бүтээгдэхүүн</u> : газрын тос зэрэг эрдэс түлш; органик химийн бодис; органик бус химийн бодис; төмөр, ган; бордоо; ундаа, спирт, цуу; төрөл бүрийн хүнсний бэлтгэлийн бүтээгдэхүүн; загас; машин механизм, компьютер; цаас, цаасан эд зүйлс. <u>Экспортын гол түншүүд</u> : АНУ 41.73%, Аргентин 6.75%, Колумби 4.07%, Перу 3.90%, Чили 3.58%. <u>Импортын гол бүтээгдэхүүн</u> : түүхий газрын тос; зорчигч тээврийн хэрэгсэл; төмрийн хүдэр ба баяжмал; өргөгч, бульдозер, грейдерийн эд анги; гар утас, видео бичигч ба радио дамжуулагч; ачааны машин; төмөр ба ган хоолой; нисэх онгоцны хөдөлгүүр; боловсруулсан газрын тос; утас, факс ба сэлгэн залгах төхөөрөмж. <u>Импортын гол түншүүд</u> : АНУ 31.95%, Габон 12.49%, Хятад 7.10%, Колумби 5.51%, ОХУ 4.88%.
Байгалийн баялаг	Газрын тос, байгалийн хий, асфальт
Гадаад өр	ДНБ-ий 52,7% (2024 оны байдлаар)
Мөнгөний нэгж, ханш	1 тринидад ба тобаго доллар 0.15 ам. доллартай тэнцэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдээнд 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурсан.

Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулснаар тус улстай дипломат харилцаа тогтоох манай улсын дотоодын процедур гүйцэлдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР